

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН 2024 ОНЫ

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц
МУ-ын хууль				
1	1	Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03	39.7. Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана.	Хээрийн түймрийн үед ажилласан авто машины шатах тослох материалыг аймгийн Засаг даргын захирамжаар 12,2 сая төгрөгний шатахууныг шийдвэрлүүлэн ажиллаж байна.
2	2	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2024 оны эхний хагас жилийн байдлаар 92,9% хангаж ажилласан.
3	3	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Төрийн бодлого хөтөлбөрийн хүрээнд Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай, тогтоомж тэдгээрийг дагалдан гарсан дүрэм, журам, Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагаа, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум модны үндэсний хөдөлгөөн, Төрийн цэргийн байгууллагын хөгжил стратеги-2030 зэрэг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/173 дугаар тушаалаар батлагдсан Хугацаат тайлан мэдээг тайлагнах, дүгнэх журмын хэрэгжилтийг хангаж ажилласан.

	5	8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Сар бүрийн 1-нд төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргаж Санхүү, төрийн сангийн хэлтэсээр баталгаажуулан, ОБЕГ-ын Санхүү, ар талын газарт хүргүүлдэг.
	6	8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	МУ-ын шадар сайдын 2023 оны 75 тушаалаар батлагдсан журмын дагуу Галын аюулгүй байдлын шаардлага хангаж хүсэлт гаргасан 84 аж ахуйн нэгж байгууллагад галын аюулгүй байдлын дүгнэлт олгон 2.200.000 мянган төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлж, бусад аж ахуйн нэгж, байгууллагад хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллаж байна.
	7	8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/103 тоот захирамж, 02 дугаар сарын 27-ний өдрийн А/125 тоот захирамж, 05 дугаар сарын 08-ны өдрийн А/271 тоот захирамж, 05 дугаар сарын 08-ны өдрийн А/276 тоот захирамж, 05 дугаар сарын 21-ний өдрийн А/300 тоот захирамж, 05 дугаар сарын 22-ны өдрийн А/301 тоот захирамж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн А/47 тоот “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах журмын 3 дугаар хавсралтын дагуу Баруун-Урт сумын 7 дугаар баг Баян шарга өргөө хотхон, 960 хүүхдийн сургууль, Шинэ тэмүүлэл хотхоны 1 дүгээр ээлж, Хос-Өргөө орон сууцны 1 дүгээр ээлж, Спорт цогцолбор, Наран сум 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, дэд станцын шинэчлэлийн ажил, Дарьганга зусланг орчин үеийн стандарт нийцсэн амралт, аялал жуулчлалын цогцолбор болгон шинэчлэх гадна инженерийн шугам сүлжээний барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комисст ажилласан

	8		8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг www.su.nema.gov.mn цахим хуудаст, Сүхбаатар Онцгой байдлын газар гэсэн фасебүүк хуудсаар үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв хүргэн ажиллаж байна.
				100
УИХ-ын тогтоол				
4	9		3. газар хөдлөлтөөс хамгаалах арга хэмжээг хот төлөвлөлтийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх, төвлөрлийг сааруулж, суурьшлын бүс, дагуул хотыг газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү төлөвлөж хөгжүүлэх арга хэмжээг авах;	Аймгийн засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 26-ний өдрийн А/71 тоот захирамжаар газар хөдлөлтийн салбар зөвлөлийг шинчилэн баталж нитй 23 гишүүнтэй байгуулан төлөвлөгөө боловсруулан ажилласан.
	10	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34	7. газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;	Монгол Улсын засгийн газрын 339 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах 16 заалт бүхий төлөвлөгөө боловсруулж бэлэн байдлыг ханган ажилласан. Гамшгийн аюулын тухай” зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт, дадлага сургуулийг зохион байгуулах ажлыг 13 сумд, гамшгаас хамгаалах орон нутгийн 12 алба, 20 мэргэжлийн анги, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, Сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийг хамруулан 837 хүнд танхимын сургалтыг зохион байгуулж ажиллана. Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх “Зарлан мэдээлэл”-ийн дуут дохио дамжуулах нэгдсэн дадлага сургуульд 4492 иргэн хамрагдсан

	11		8. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх.	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн 4 бүлгийн 15 заал бүхий төлөвлөгөө боловсруулан 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг гарган ажилласан. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2024 оны ээлжит хуралдаанаас гарсан 01 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалтын дагуу Гамшгийн эрсдэлийн санд урьдчилан сэргийлэх аврах, хор уршгийг урилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний зохион байгуулалтын үйл ажиллагаанд зарцуулах 900.0 сая төгрөг батлуулсан. Үүнээс 2024 оны эхний хагас жилд аймгийн өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал, зудын эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээнд нийт 623,9 сая төгрөг зарцуулсан.
Ерөнхийлөгчийн зарлиг				
5	12	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Онцгой байдлын газрын гэрэлт хаяг, албан тушаалтны өрөөний хаяг, нэрийн хуудас зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлсэн, "Монгол хэлний тухай хууль" Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хүрээнд 2025 онд төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг эрчимжүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуультай хамтран алба хаагчдын үндэсний бичгийн түвшинг тодорхойлон, сургалт зохион байгуулж ажиллаж байна.
6	13	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах	2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын	Онцгой байдлын ерөнхий газрын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 3/2363 тоот албан бичгээр ирүүлсэн үүргийг

		тухай 2022-07-11 Дугаар 2022_159	байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.	хэрэгжүүлэх ажлын хүрээнд Зэвсэгт Хүчний Жанжин Штабын даргын 2023 оны А/131 дүгээр тушаалаар батлагдсан Цэргийн албыг зохион байгуулах зааврын хоёрдугаар бүлгийн 2.4-т заасны дагуу тус Онцгой байдлын газрын даргын өрөөний хананд Монгол Улсын Төрийн сүлдийг голлуулан байрлуулж, баруун талд эзэн Богд Чингис хааны бага эш хөрөг, зүүн талд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт Хүчний Ерөнхий Командлагчийн цээж хөргийг тус тус хүндэтгэн байрлуулсан. Байгууллагын үйл ажиллагаанд “Төрийн бэлгэ тэмдгийн тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Онцгой байдлын газрын хүндэтгэлийн өргөөнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 159 дүгээр зарлигийн хоёрдугаар зүйлд заасны дагуу эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залж, эзэн Богд Чингис хааны суу алдар, агуу их түүхэн үйл хэргийг сурвалжлан судлах, түгээн дэлгэрүүлэх, эрхэмлэн дээдлэх, алдаршуулан мөнхжүүлэх, төрт ёсны үнэт өвийг бэхжүүлэх, эв зөийг бататгах үйл хэргийг иргэд, олон нийтэд сурталчилан таниулж байна.
ҮАБЗ-ийн зөвлөмж				
7	14	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09	3. Газар хөдлөлтийн аюул, гамшигтай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тогтмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооцдог байх,	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ийг хэрэгжүүлэх ажлыг хүрээнд жил бүрийн 03 дугаар сарын 4 дэх долоо хоногийн Пүрэв гарагийн 16:00 цагт Улс орон даяар “Зарлан мэдээлэл”-ийн дуут дохио дамжуулах дадлага сургуулийг зохион байгуулан ажиллаж аймгийн гамшгаас хамгаалах алба, тусгай болон

				ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн нийт 756 хүн, төрийн болон тусгайлсан чиг үүрэг бүхий 5 байгууллагын 184 хүн, 42 аж ахуйн нэгж, байгууллагын 2554 иргэд, олон нийтийг хамруулсан 956 иргэн тухайн сум, баг, хорооны аюулгүй талбайд тус тус гарч нэгдсэн арга хэмжээнд нийт 4492 иргэн 34 автомашин, техник хамрагдсан. Онцгой байдлын газраас 59 алба хаагч, дуут дохиот 3 автомашинтай иргэдэд мэдээлэл хүргэн ажилласан. Тус дадлага сургуулилтад боловсролын 41 байгууллагыг хамруулан ажилласан.
ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл				

	17		6. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед авран хамгаалах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтарсан гэрээ, бүх нийтийг хамарсан иргэний хамгаалалтын албан ба албан бус сургалтын хөтөлбөр боловсруулж, сургуулилт зохион байгуулж хэвших, (Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Зэвсэгг хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга)	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ийг иргэд, олон нийтэд сурталчлах, таниулах, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, нутгийн захиргааны байгууллага, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөөний биелэлтийг хэрэгжүүлэх, газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах талаар ойлголт, урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээллийг түгээх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг жил бүр зохион байгуулж Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хүрээнд 13 сумд, гамшгаас хамгаалах орон нутгийн 11 алба, 20 мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдээлэл хүргэн бэлтгэл ажлыг хангуулан албан бичгээр үүрэг чиглэлийг хүргүүлж, заавар зөвлөгөө өгч удирдлагаар хангаж ажилласан. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед авах арга хэмжээ” сэдвээр гамшгаас хамгаалах орон нутгийн 11 алба, 20 мэргэжлийн ангийн төлөөлөл, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагчдын хамруулан 27 удаагийн 29 цагийн сургалтыг 837 хүнд танхимаар зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.
--	----	--	--	---

--	--	--	--	--

	18		7.. Гамшгийн үед онцгой горимоор ажиллах шаардлагатай дулааны цахилгаан станц, цахилгаан, дулааны эрчим хүч дамжуулах, түгээх байгууламж, тээвэр, ачаа, зорчигчийн терминал, харилцаа холбоо, телевиз, радио зэрэг дэд бүтцийн объектууд, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, химийн болон бусад хорт бодис, нян өсгөвөр бүхий газруудын аюулгүй ажиллагааны журам, зааврыг боловсруулж хэрэгжүүлэх, (Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг дарга)	Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд 02 дугаар сарын 08-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдөр хүртэл Шатахуун түгээх станц /ШТС/, Автомашин хийгээр цэнэглэх станц /АХЦС/, Хий цэнэглэх станц /ХЦС/-ын барилга байгууламжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж илэрсэн зөрчлийг тухай бүр нь арилгуулж Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн эрх зүйн бичиг баримтыг хүргүүлсэн. Мөн гал түймрийн онц аюултай объектын аюултай ачаа тээвэрлэх автомашины судалгаа, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, хүүхдийн дотуур байр, хэвтэн эмчлүүлэх эмнэлэг зэрэг байгууллагын алслагдсан зай /км/ судалгааг гарган ажиллаж байна. Удирдамжийн хүрээнд Цайрт менерал ХХК-ни, Эрдэнэцагаан сумын хилийн 0146 дугаар ангийн нийт 254 ажилтан алба хаагчдад Галын аюулгүй байдлын тухай хууль, Шатамхай хийн галын аюулгүй байдлыг хангах, Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага MNS 4978:2017 зэрэг холбогдох хууль стандарт, норм нормативаар 4 өдөр 8 цагийн танхимийн сургалтыг зохион байгуулж ажилласан.
ЗГ-ын тогтоол				

9	19	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	Онцгой байдлын газрын Сүхбаатар Онцгой байдал газар facebook болон Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газар пайж хуудсанд нийтэлж байгаа урьдчилан сэргийлэх болон цаг үеийн мэдээ, мэдээлэл, монгол бичгээр хөрвүүлэн кирилл, монгол бичгийн хамт зэрэгцүүлэн байршуулан хүргэж байна. Монгол Улсын Засгийн газрын Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022 оны 7 дугаар тогтоолын дагуу байгууллагын албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөх ажлыг эхлүүлсэн. Онцгой байдлын газрын даргын 2024 оны А/01 “Онцгой байдлын газрын алба хаагчдын мэдлэг, дадал, ур чадварыг дээшлүүлж, бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах” 2024 оны хичээлийн цаг сэдвийн төлөвлөгөөг боловсруулж тушаалаар баталгаажуулсан. “Монгол хэлний тухай хууль” Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хүрээнд 2025 онд төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг эрчимжүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуультай хамтран алба хаагчдын үндэсний бичгийн түвшинг тодорхойлон, сургалт зохион байгуулж ажиллаж байна.
---	----	---	--	---

10	20	Улсын нөөцөөс бараа материал гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай 2023-12-13 Дугаар 2023_449	3.3 Улсын нөөцөөс олгох тэжээлийг оновчтой хуваарилах, зориулалтын бусаар зарцуулах, худалдаалахаас урьдчилан сэргийлж, хяналт тавих, гүйцэтгэлийн тайланг холбогдох баримтын хамт 2024 оны I улиралд багтаан Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засагдарга нарт даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 449, 2024 оны 479 дүгээр тогтоолийн дагуу Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын 144 дүгээр салбар, 016 дугаар цэгээс аймгийн Засаг даргын 2024 оны А/17, А/101 дүгээр захирамж, батлагдсан хуваарийн дагуу Мөнххаан, Сүхбаатар, Түвшинширээ, Уулбаян, Түмэнцогт, Асгат, Баяндэлгэр, Дарьганга, Наран, Онгон, Халзан, Эрдэнэцагаан, Баруун-Урт сумдад нөөцийн бараа, материалыг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр бүрэн олгосон. 449, 479 дүгээр тогтоолоор олгосон нөөцийн бараа, материалын борлуулалтын орлогыг ОБЕГ-ын дансанд бүрэн төвлөрүүлж, тогтоолын биелэлт, тайлан холбогдох баримтыг Улсын нөөцийн газарт цахимаар болон бичгээр хугацаанд нь хүргүүлсэн.
11	21	Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_62	2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай. (1.Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан зудын эрсдэлийг бууруулах, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.)	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 ¹ дүгээр зүйлийн 27 ¹ .1.1, 27 ¹ .1.4, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын даргын 2023 оны 8 дугаар тушаалыг үндэслэн Аймгийн засаг даргын А/692 захирамжаар өвөлжилтийг даван туулах, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор аймгийн Шуурхай штабыг байгуулж хуваарь гарган 24 цагаар үүрэг гүйцэтгүүлэн ажиллаж УОК-ыг мэдээ мэдээлэлээр ханган ажиллаж баяа. Аймгийн засаг даргын А/04 захирамжаар зудын гамшигтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллаж байна.

ЗГ-ын хуралдааны тэмдэглэл				
12	22	2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2022-04-20 Дугаар 2022_24	XIY.5. Ой, хээрийн түймрийн цагийн байдлын талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлж, хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэхэд дэмжлэг үзүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, байгаль хамгаалагч нарын хариуцлагыг өндөржүүлэх, ард иргэдэд хүргэх сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023 оны 04 дүгээр сарын 04-ны өдрөөс эхлэн 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийг хүртэл хугацаанд Онцгой байдлын газраас 5 алба хаагч, Эрдэнэцагаан сумын ЗДТГ-ын 18 алба хаагч, 5 автомашин тус тус хамтран түймэр гарах эрсдэлтэй Эрдэнэцагаан сумын Хөндлөн хайлааст 1-р баг, Хонгор 3-р баг, Бадрах 4-р баг, Жаргалант 6-р баг, Хадын булан 7-р багийн Уртын цагаан, цоржин, Хангай, Шудалдай уул, Нүхт, Хөшөөт, Хэрэстэй хоолой, Шилийн цагаан, Оросын айраг, Энгэр шанд, Бор өнлөр, Модон гуу, зэрэг газруудад хаваржиж байгаа 230 малчин өрхийн 806 иргэнд брошур, гарын авлага тарааж айл өрхийн 3-н угт хаяг байршил, утасны дугааруудыг бүртгэж хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж өгч, тээврийн хэрэгслийн галын аюулгүй байдал хангах, үнс нурмаа ил задгай газар асгахгүй байх талаар зөвлөн туслах үйлчилгээ өгч, what 3 words апплейкшний ач холбогдол ажиллах зарчмын талаар мэдээлэл хүргэж нийт 1.368.000 төгрөгийг урьдчилан сэргийлэх ажилд зарцуулж ажилласан. Галын аюулгүй байдлын тухай хууль, Гал түймрийн улсын хяналтын дүрэм, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулахаар Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйл: Галын аюулгүй байдлыг хангах нутгийн захиргааны байгууллага, сумын Засаг дарга дараах үүргийг хэрэгжүүлж ажиллах, талаар гал түймрийн улсын хяналтын байцаагчийн “АЛБАН МЭДЭГДЭЛ”-ИЙГ 13 сумын засаг даргад

				хүргүүлсэн.
13	23	2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2023-04-26 Дугаар 2023_18	XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Онцгой байдлын газрын “Сүхбаатар онцгой байдлын газар” facebook, фэйж хуудас болон сумдын цахим хаягт хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг зөвлөмж мэдээллийг 21 удаа. цаг үеийн нөхцөл байдлын мэдээллийг 12 байршуулж иргэдэд хүргэн 32926 хүний хандалт авсан. Орон нутгаас хэвлэгдэн гардаг Сүхбаатарын өнгө сонинд шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээ мэдээллийн талаар 3 удаа нийтлүүлэн, ухуулга сурталчилгааны 1500 ширхэг санамж, гарын авлага иргэдэд хүргэн тараан ажиллалаа. Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн Сүхбаатар аймгаас Асгат, Эрдэнэцагаан, Дарьганга сумдын түймрийн эрсдэлтэй бүс нутагт зорчиж байгаа 116 тээврийн хэрэгслийн жолооч болон 327 иргэдэд 1500 ширхэг санамж материал ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулан хөдөлгөөнт постыг ажиллуулж байна.
14	24	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23	XXII.2.. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов:	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг www.su.nema.gov.mn цахим хуудаст, Сүхбаатар Онцгой байдлын газар гэсэн фэсебүүк хуудсаар үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв хүргэн ажиллаж байна. (shilen.gov.mn) сайтад мэдээ мэдээллийг холбогдох линк хаягаар байршуулан ажиллаж байна.

			1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.	
16	26	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэл 2023-12-06 Дугаар 2023_49	XIII.2. Зарим аймагт өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт үүрэг болгов.”	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.1, 27¹.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын даргын 2023 оны 8 дугаар тушаалыг үндэслэн Аймгийн засаг даргын А/692 захирамжаар өвөлжилтийг даван туулах, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор аймгийн Шуурхай штабыг байгуулж хуваарь гарган 24 цагаар үүрэг гүйцэтгүүлэн ажиллаж УОК-ыг мэдээ мэдээлэлээр ханган ажиллаж байна2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллаж байна.

